



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 10 сарын 11 өдөр

Дугаар 1/393

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд хэрэгжих Нэгдсэн эмнэлгийн төрөх тасгийн бохирын шугамын засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Ц. Дэмбэрэлсайхан -Орон нутгийн өмчийн газрын дарга

Нарийн бичгийн дарга: О. Сэдэд -Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

Гишүүн: Б. Содбилэг -Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг ажлын хэсгийн дарга /Ц. Дэмбэрэлсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н. ГАНБЯМБА

